



Үзэл бодолтой байх, түүнийгээ
илэрхийлэх эрх чөлөө:
Монголын хууль тогтоомж

Хуульч Д.Мөнхбүрэн

Улаанбаатар
2016.11.23

ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Үндсэн хууль,
10, 16.16, 16.17

Олон Улсын гэрээ
ИУТЭТОУП, ХЭТТ

Хэм хэмжээ тогтоосон
захиргааны акт

Өөрийн
зохицуулалтын хэм
хэмжээ

МУ-ын Үндсэн хууль

Монгол Улсын иргэн дараахь үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ:

16.16. Итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх

16.17. Төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар **мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй**. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг

хангах зорилгоор задруулж үл болох **Төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар** тогтоон хамгаална.

Үндсэн үүргийг ёсчлон биелүүлнэ:

- 1/ Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх;
- 2/ хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх;

ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ

- 13 дугаар зүйл. Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүрэг
- 13.1. Төрийн жинхэнэ албан хаагч нь дараахь нийтлэг үүрэг хүлээнэ:
 - 13.1.8. албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ улс төрийн аливаа нөлөөлөлд автахгүй төвийг сахих, **хэвлэл, мэдээллийн хэрэгслээр төр, засгийн бодлоготой холбогдсон асуудлаар зөвхөн албан ёсны байр суурийг илэрхийлэх;**
- Прокурорын байгууллагын тухай
- Хүний эрхийн үндэсний комиссын тухай
 - “Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх эдлэхдээ өөрийн албан тушаалдаа хүндэтгэлтэй хандана”

Цензурын хэлбэр

- Төрийн цензур
- Захиргааны цензур
- Эдийн засгийн цензур
- Айлган сүрдүүлэлт
- Редакцийн цензур
- Өөрийн цензур

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль




Дагалдах журам, стандарт

- “Мэдээлэл өгөх үйлчилгээний хөлс төлөх, түүнээс хөнгөлөх, чөлөөлөх журам”, Засгийн газрын тогтоол, 2013 оны нэгдүгээр сар
- “Мэдээллийн ил тод байдлыг хангах нийтлэг журам”, ЗГ-ын 2013 оны 411-р тогтоол,
- Нийтийн зар мэдээний үлгэрчилсэн журам, ЕТГ, 2013 он,
- Төрийн байгууллагын вэб сайтад тавих шаардлага MNS 6285-2011 стандартыг Стандартчлал хэмжилзүйн үндэсний төв
- Эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагааг үнэлэх шалгуур үзүүлэлт, АТГ-ын даргын 2016 оны А/54 тушаал

Мэдээлэл хүсэгчийн эрх

Мэдээлэл хүсэх, хүлээн авах хэлбэр




-Шууд өгөх
-Ажлын 7 хоногт



Шаардлагатай үед хугацааг дахин 7 хоногоор сунгаж болно.

Мэдээлэл түгээх суваг

- Мэдээллийн самбар
- Цахим хуудас
- Хэвлэмэл болон хэвлэмэл бус байдлаар
- Хэвлэл мэдээллийн хэрэгсэл



14 хоног тутам нэгээс доошгүй удаа шинэчлэх

Тухайн мэдээлэлд нэмэлт, өөрчлөлт орсон, эсхүл мэдээлэл бүхэлдээ өөрчлөгдсөн тохиолдолд уг мэдээллийг 3 хоногийн дотор шинэчлэх

Тухайн мэдээлэлтэй танилцах нөхцөл бүрэн хангагдсан байх

- Төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангахад дагаж мөрдөх журам 5-р зүйлд
 - Мэдээллийн самбар нь 1,5м багаггүй хэмжээтэй.
 - Ил тод байх мэдээлэл бүрийн шинэчлэгдэх хугацааг зааж өгсөн.



-ШАЛТГААНАА АЛБАН ТУШААЛТАН ТАЙЛБАРЛАХ ҮҮРЭГТЭЙ

-МЭДЭЭЛЭЛ АВАХ ЗОРИЛГОО ТАЙЛБАРЛАХГҮЙ БАЙХ ЭРХТЭЙ

Гомдол гаргах



- сахилгын шийтгэл
- Төрийн албанаас халах
- Шийдвэр гаргах эрх бүхий этгээдийг ХХДХ: 5 дахин

СЭТГҮҮЛЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

- **Эрүүгийн хууль (139.1, 139.2), 2002**


Сэтгүүлчийн хуульд нийцсэн мэргэжлийн үйл ажиллагаанд саад хийх нь гэмт хэрэгт тооцно

- **Иргэний хууль, (498.1), 2002**

Ажиллагсад хөдөлмөрийн гэрээ буюу албан тушаалын дагуу хүлээсэн үүргээ гүйцэтгэх явцад гэм буруутай үйлдэл, эс үйлдлээрээ бусдад учруулсан гэм хорын харицулагыг түүнийг ажиллуулж байгаа ажил олгогч хүлээнэ.



- Төрийн нууцын тухай хууль
- Төрийн нууцын жагсаалт батлах тухай хууль
- Эрүүгийн хууль
- Үндэсний аюулгүй байдлын тухай хууль



Байгууллагын нууцын тухай хууль

- 3.2. Хуульд өөрөөр заагаагүй бол байгууллагын албан үйл ажиллагааны онцлогтой холбоотой, эсхүл шударга өрсөлдөөнд зах зээл, давуу талаа хамгаалах зорилгоор байгууллага өөрөө нууцалж хамгаалалтдаа авсан, задруулбал хууль ёсны ашиг сонирхолд нь хор уршиг учруулж болох нууц мэдээ, технологийн шийдэл, төсөл, судалгаа-шинжилгээний баримт бичиг, шаардлагатай техник, тоног төхөөрөмжийг байгууллагын нууцад хамааруулж болно.
- Энэ хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт хамаарах нууцыг **байгууллага өөрөө тогтооно**.

Хувь хүний нууцын тухай

- “Тухайн хүний хууль ёсны ашиг сонирхол, нэр төр, алдар хүндэд илтэд хохирол учруулж болзошгүй мэдээ, баримт бичиг, биет зүйлийг хувь хүний нууц гэнэ”
 - захидал харилцааны
 - эрүүл мэндийн
 - хөрөнгийн
 - гэр бүлийн
 - бусад

- **ЖИРИЙН ИРГЭН**



- **УЛС ТӨРЧ, НИЙГМИЙН АЛДАРТАН**
- **УРЛАГ СОЁЛЫН ОДОД**
- **ТОХИОЛДЛООР АЛДАРТАН БОЛОГЧ**
- **ХААН ХАТНЫ ГЭР БҮЛ**

10.2. Мэдүүлэг гаргагч нь **өөрийн болон гэр бүлийн гишүүдийн хөрөнгө, орлого, зээлийг** үнэн зөв мэдүүлэх үүрэгтэй. /Авлигын эсрэг хууль/

25. Албан тушаалтны **хувийн ашиг сонирхлын мэдүүлэг нээлттэй** байна. /Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай/

Захиргааны ерөнхий хууль

- Захиргааны байгууллага
 - Үйлчилгээг нь нийтээс заавал хэрэглэдэг төрийн ба холимог өмчийн ... хэвлэл мэдээлэл...-ийн байгууллагын захиргаа /5.1.4/

Албан тушаалтан хууль зөрчиж гаргасан захиргааны актаа хүчингүй болгосон тохиолдолд тухайн акт хувь хүнд чиглэсэн бол ганцаарчилсан уучлалт, харин хэд хэдэн хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн захиргааны актыг хүчингүй болгосон тохиолдолд энэ хуулийн 105.2-т заасан шийтгэлээс аль нэгийг оногдуулахаас гадна энэ талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан тэднээс уучлалт хүснэ. /105.3/

Агуулгын зохицуулалт,
хязгаарлалт

Зар сурталчилгааны тухай хууль

- Зар сурталчилгаа нь үнэн, хэрэглэгчдэд хүртээмжтэй байж, агуулга, хэлбэр, түүнийг түгээж байгаа арга хэрэгслээс үл хамааран зар сурталчилгаа гэж ойлгогдохоор байна
- 7.1.Хууль бус зар сурталчилгаанд зүй бус, бодит байдалд үл нийцсэн, ёс суртахуунд үл нийцсэн, далд зар сурталчилгаа хамаарна.

Оюуны өмчийн улсын хяналтын алба, Өрсөлдөөний тухай хуульд заасан асуудлаар Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар

11 дүгээр зүйл. Радио, телевизээр түгээх зар сурталчилгаа

- 11.1. Уран сайхны болон баримтат кино, радио жүжгийн дундуур зар сурталчилгаа нэвтрүүлэхдээ зохиогч, эсхүл зохиогчийн эрх эзэмшигчийн зөвшөөрлийг авсан байна.
- 11.2. Хүүхдэд зориулсан нэвтрүүлгийн дундуур зөвхөн хүүхдэд зориулсан зар сурталчилгаа нэвтрүүлж болно.
- 11.3. Улс орны болон дэлхий дахины амьдралын цаг үеийн шинжтэй үйл явдлын талаархи тогтмол мэдээллийн дундуур зар сурталчилгаа нэвтрүүлэхийг хориглоно.
- 11.4. Сургалтын нэвтрүүлгийн дундуур зөвхөн сургалттай холбоотой бөгөөд 5 минутаас илүүгүй хугацаанд 30 секундээс дээшгүй үргэлжлэх зар сурталчилгааг нэвтрүүлж болно.
- 11.5. Үргэлжлэх хугацаа нь 20 минутаас дээшгүй нэвтрүүлгийн дундуур зар сурталчилгаа нэвтрүүлэхийг хориглоно.
- 11.6. Орон нутгийн цагаар 22 цагаас 06 цаг хүртэл 18 хувь хүртэл этилийн спирт агуулсан дарс, пиво, шимийн архины зар сурталчилгаа нэвтрүүлж болно.

АГУУЛГЫН ЗОХИЦУУЛАЛТ

- Терроризмтой тэмцэх тухай
- Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хууль
- Зар сурталчилгааны тухай
- Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн хүүхдийн хүмүүжил, ёс суртахуунд сөрөг нөлөө үзүүлсэн;
- Садар самуун явдалтай тэмцэх тухай
- Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль
- Эрүүгийн хуулийн үндэсний эв нэгдлийг бусниулах, терроризмийг сурталчилсан, нийтийн эмх замбараагүй байдалд өдөөн турхирсан, шашны харгис үзэл номлолыг сурталчилсан г.м
- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль
- Бусад

ХМХ-ийн бүртгэл, Өргөн
нэвтрүүлгийн тусгай
зөвшөөрөл

Радио долгионы тухай хууль

- Монгол Улсад өргөн нэвтрүүлэг болон цахим мэдээллийн хэрэгслийн тухай хууль байхгүй.
- “Радио долгион нь Монгол Улсын төрийн өмч бөгөөд радио давтамж, давтамжийн зурвас хуваарилах эрх дан ганц Засгийн газарт байна” /Радио долгионы тухай хууль/
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулиар тусгай зөвшөөрөл олгодог

Өргөн нэвтрүүлгийн хэрэгсэл нь өөрөө хязгаарлагдмал нөөц долгионыг ашигладаг тул түүнд хараат бус зохицуулалт шаардагддаг.

“Харилцаа холбооны тухай”

- ХХЗХ-г 1995 онд байгуулсан.
- Зохицуулах хороо нь дарга, орон тооны бус 6 гишүүнээс бүрдэж, “Зохицуулах хорооны дарга, гишүүнд харилцаа холбооны салбарт өндөр мэргэжил, ажлын туршлага бүхий удирдан зохион байгуулах чадвартай, сайдын санал болгосныг үндэслэн Ерөнхий сайд томилно”
- Зохицуулах хорооны жилийн төсвийг Засгийн газар батална, хэрэгжүүлэгч байгууллага

Олон улсын эрх зүйн жишгээр хэвлэл мэдээллийн салбарыг зохицуулах эрх мэдэл бүхий байгууллага нь Засгийн газраас хараат бус байж, нийтийн өмч болсон долгионы давтамжийн зурвас хуваарилалтыг зохицуулах ёстой байдаг

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль

- 7.1.Хуулийн этгээдийг дор дурдсан байгууллага
 - хэвлэл мэдээллийн хэрэгслийг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, түүний орон нутаг дахь салбар;

“ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЭЛ”-ИЙГ ШИНЭЭР БАЙГУУЛАХАД БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧИГ



2013 оны 7-р сарын 04, Пүрэв гариг, 18:32

1. Хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэх өргөдөл УБ03 маягт 2 хувь
2. Нэрийн баталгаажуулалтын хууда
3. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл үүсгэн байгуулах, редакцийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг баталсан үүсгэн байгуулагчийн шийдвэр /1-ээс дээш үүсгэн байгуулагчтай бол хурлын тогтоол, хурлын тэмдэглэл/
4. Дүрэм 3 хувь /**Төрийн бус байгууллагын тухай хуулийн 10 дугаар зүйлийн дагуу**/
5. Редакцийн зөвлөлийн бүрэлдэхүүнээс дарга, гүйцэтгэх удирдлагыг томилсон хурлын тэмдэглэл, хурлын тогтоол /2 хувь/
6. Хуулийн этгээдийн харилцах данс нээлгэсэн мэдэгдэл
7. Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт. /22000 төгрөг.Голомт банк 1401002649, Хас банк 5001122188 тоот дансанд тушаана./
8. Үүсгэн байгуулагч болон редакцийн зөвлөлийн гишүүдийн иргэний цахим үнэмлэхний хуулбар /2 хувь/
9. Эхлэлтийн тайлан тэнцэл /2 хувь/
10. Бусад холбогдох материал /бэлэн мөнгө тушаасан баримт, хөрөнгийн жагсаалт, түрээсийн гэрээ г.м/

Анхаарах зүйлс:

- Тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх бол эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн хуулбар /**радио телевизэд хамаарна**/
- УБ 03 маягт, хурлын тогтоол, хурлын тэмдэглэлд үүсгэн байгуулагч, тэргүүлэгч бүр гарын үсэг зурж баталгаажуулах.
- Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт./Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд заасны дагуу/
- №1,2 цонхноос данс нээх мэдэгдэл авч банкинд очиж дансаа нээлгүүлнэ.
- Бүрдүүлсэн баримт бичгийг архивын шаардлага хангах хавтсанд хийх.

Сүүлд шинэчлэгдсэн: 2014 оны 11-р сарын 17, Даваа гариг, 12:44

ХМ-ийн өмчлөлийг зохицуулах шаардлага?

- Хэвлэл мэдээллийн хэрэгслийг өмчлөгч түүний агуулгад нөлөөлөх боломжтой байдаг бөгөөд тийм нөлөөгөө ашиглахыг завдсан ямар ч оролдлогыг **хязгаарлах нь** зөв юм. Хэвлэл мэдээллийн хэрэгслийг өмчлөгчид түүний агуулга ямар байхыг зааварладаг.
- **Цөөн өмчлөгч байна гэдэг нь цөөн төрлийн агуулга байна гэсэн хэрэг.**
- Хэвлэл мэдээллийн төвлөрөл нь түүний **агуулга** төдийгүй **нэвтрүүлэх арга хэлбэрт** ч нөлөөлж байдаг.

ХХЗХ-НЫ ЖУРАМ

- Тоон контентийн үйлчилгээний зохицуулалтын ерөнхий нөхцөл шаардлага, 2011.2.17
 - Агуулгад тавигдах шаардлага
 - Бэб сайтын үйлчилгээ эрхлэгчдэд тавигдах нөхцөл шаардлага
 - Хяналт
 - Гомдол маргаан шийдвэрлэх
 - хариуцлага
- Өргөн нэвтрүүлгийн зохицуулалт, нөхцөл шаардлага, 2015 оны 15-р тогтоол
 - Эзэмшлийн ил тод байдал
 - тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд тавиглах ерөнхий шаардлага
 - Хөтөлбөрт тавигдах ерөнхий шаардлага
 - Үйлчилгээ эрхлэгчдэд тавигдах нөхцөл шаардлага
 - ёс зүй
 - Хяналт
 - Хариуцлага

**Анхаарал тавьсанд
баярлалаа**

